

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Статистикийн хэлтэс 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/125/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 99092469 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Лүндэгмаа
Утас: 99026829 Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn
Аудитор: Б.Эрдэнэтунгалаг
Утас: 99063931 Цахим хаяг: sain.audit5831@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
3.1	(Аудитын чиглэл).....	
3.1.1	Илрүүлэлт:.....	
3.1.2	Эрсдэл:	
3.1.3	Өгсөн зөвлөмж:	
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	
3.2	(Аудитын чиглэл).....	
3.2.1	Илрүүлэлт:.....	
3.2.2	Эрсдэл:	
3.2.3	Өгсөн зөвлөмж:	
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	

1 Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019.02.22 № 1-6/113

танай _____ -ны № _____ -г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Статистикийн хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.


Зөрчилгүй санал дүгнэлт

Статистикийн хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Статистикийн хэлтсийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.



Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Статистикийн хэлтсийн удирдлага Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б. АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Х.Өлзийсүрэнд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018.01.30-наас 2018.01.31–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018.02.20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019-ны өдрийн 11 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Статистикийн хэлтэс нь Албан ёсны статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан зарчмын дагуу аймаг, орон нутгийн хэмжээнд төвлөрүүлэн эрхэлж, үнэн бодит, чанартай мэдээлэл, судалгаагаар хэрэглэгчдэд үйлчлэн статистикийн талаарх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахад оршино. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- НДШ-ийн тухай хууль
- ХХОАТатварын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагаанд Статистикийн тухай хуулийг мөрдлөг болгон ажиллаж байна

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acoulous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5

асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт орлого* -ын 2 хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдагтай холбоотой юм.

Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн 2018 оны *Нийт орлого* 286233,0 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 2,862.33 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	1,687.50	
	Дүн	1	1,687.50	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал илэрсэнгүй. :

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Статистикийн хэлтэс чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой нэг хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 64047,0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 63926,5 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байгаа нь зарим зардал 120,5 мянган төгрөгөөр хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, МонголУлсынхолбогдоххуультагтоомжиднийцүүлэнгүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

3.1.1 Илрүүлэлт

Мөнгөн хөрөнгийн журналаас гүйлгээг түүвэрлэн шалгахад 1.6 сая төгрөгөөр автомашиныг жолоочтой нь түрээслэх гэрээ байгуулж шилжүүлсэн боловч гэрээг дүгнэж тооцоог бодоогүй, жолоочийн тооцооны хуудсан дээр жолооч болон хянасан нягтлан бодогчийн гарын үсэг, дагалдах хуудас байхгүй байна.

3.1.2 Эрсдэл

Санхүүгийн тайлангууд буруу илэрхийлэгдэх “Үнэлгээ”, “Хэмжилт”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүд зөрчигдөх

3.1.3 Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дахь заалтын дагуу нягтлан бодогч нь анхан шатны баримтыг бүрдүүлж, гарын үсэг тамга тэмдгийг бүрэн зуруулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад (2019 оны 06 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,542,988.10	3,995,298.10
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
3121	Төгрөг	00.00	00.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,542,988.10	3,995,298.10
354	Хангамжийн материал	2,542,988.10	3,995,298.10
35410	Бичиг хэргийн материал	255,220.00	920,430.00
35420	Аж ахуйн материал	2,249,368.10	2,402,368.10
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	504,500.00
35440	Түлш, шатах тослох материал	38,400.00	168,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	25,472,821.09	25,072,896.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	25,472,821.09	25,072,896.58
392	Биет хөрөнгө	25,472,821.09	25,072,896.58
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,000,000.00	30,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	-
		11,250,000.09	16,250,000.13
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	29,821,600.74	29,821,600.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	-
		23,577,922.85	25,388,846.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,556,244.00	12,556,244.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,077,100.71	-5,666,101.70
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	28,015,809.19	29,068,194.68
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
413	Өглөг	00.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	28,015,809.19	29,068,194.68
51	Засгийн газрын хувь оролцоо	28,015,809.19	29,068,194.68
512	Хуримтлагдсан үр дүн	28,015,809.19	29,068,194.68
51210	Өмнөх үеийн үр дүн	28,015,809.19	28,015,809.19
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,052,385.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	28,015,809.19	29,068,194.68

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	120,921,958.22	143,116,668.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,102,358.22	8,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	50,102,358.22	8,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,102,358.22	8,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	48,461,858.22	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,640,500.00	8,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	70,819,600.00	135,116,668.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	70,819,600.00	64,047,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	70,819,600.00	64,047,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	71,069,668.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	71,069,668.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	130,419,216.07	142,064,282.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	130,419,216.07	142,064,282.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	126,777,615.64	141,415,803.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	71,031,366.57	72,999,107.61
210101	Үндсэн цалин	45,027,859.00	59,342,028.00
210102	Нэмэгдэл	11,112,700.00	5,930,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,961,600.00	2,213,837.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,929,207.57	5,512,442.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,654,461.00	8,762,257.00
210201	Тэтгэврийн даатгал	5,586,682.77	6,895,280.00
210202	Тэтгэмжийн даатгал	413,555.48	469,523.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	516,945.03	375,659.00
210204	Ажилгүйдлийн даатгал	103,388.62	93,865.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,033,889.10	927,930.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,968,276.00	18,019,206.50
210401	Бичиг хэрэг	550,880.00	677,825.00
210402	Тээвэр, шатахуун	10,134,456.00	15,607,702.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,258,940.00	1,709,679.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,000.00	24,000.00
2105	Нормативт зардал	00.00	444,000.00
210502	Хоол, хүнс	00.00	444,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	101,000.00	11,000.00
210604	Урсгал засвар	101,000.00	11,000.00
2107	Томилолт, зочны зардал	13,024,000.00	10,204,200.00
210702	Дотоод албан томилолт	13,024,000.00	10,204,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,858,310.00	22,187,108.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	11,075,518.00	20,923,516.00

Статистикийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	213,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	333,350.00	335,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	103,142.00	103,142.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,146,500.00	592,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,140,202.07	8,788,924.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,658,144.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	408,000.00	389,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,074,058.07	8,399,924.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,641,600.43	648,478.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,627,990.00	528,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,627,990.00	528,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,610.43	120,478.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,610.43	120,478.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-9,497,257.85</u>	<u>1,052,385.49</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-9,497,257.85</u>	<u>1,052,385.49</u>

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	121,650,268.00	135,116,668.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,830,668.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	50,830,668.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,830,668.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,830,668.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	70,819,600.00	135,116,668.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	70,819,600.00	64,047,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	70,819,600.00	64,047,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	71,069,668.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	71,069,668.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	121,650,268.00	135,116,668.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	121,650,268.00	135,116,668.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	118,008,667.57	134,468,189.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	71,031,366.57	72,999,107.61
210101	Үндсэн цалин	45,027,859.00	59,342,028.00
210102	Нэмэгдэл	11,112,700.00	5,930,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,961,600.00	2,213,837.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,929,207.57	5,512,442.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,654,461.00	8,762,257.00
210201	Тэтгэврийн даатгал	5,586,682.77	6,895,280.00
210202	Тэтгэмжийн даатгал	413,555.48	469,523.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	516,945.03	375,659.00
210204	Ажилгүйдлийн даатгал	103,388.62	93,865.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,033,889.10	927,930.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,951,530.00	18,413,616.50
210401	Бичиг хэрэг	521,400.00	789,635.00
210402	Тээвэр, шатахуун	10,098,790.00	14,681,497.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,258,940.00	2,765,484.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	72,400.00	177,000.00
2105	Нормативт зардал	00.00	444,000.00
210502	Хоол, хүнс	00.00	444,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	101,000.00	515,500.00
210604	Урсгал засвар	101,000.00	515,500.00
2107	Томилолт, зочны зардал	13,024,000.00	10,204,200.00
210702	Дотоод албан томилолт	13,024,000.00	10,204,200.00

Статистикийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,701,810.00	22,585,008.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,075,518.00	20,923,516.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	213,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	333,350.00	335,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	103,142.00	103,142.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	990,000.00	990,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,544,500.00	544,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	544,500.00	544,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,641,600.43	648,478.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,627,990.00	528,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,627,990.00	528,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,610.43	120,478.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,610.43	120,478.89
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	00.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	37,513,067.04	00.00	37,513,067.04
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	37,513,067.04	00.00	37,513,067.04
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-3,816,640.61	00.00	-3,816,640.61
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	28,015,809.19	00.00	28,015,809.19
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	28,015,809.19	00.00	28,015,809.19
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,052,385.49	00.00	1,052,385.49
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	29,068,194.68	00.00	29,068,194.68

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,047,000.00	63,926,521.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,047,000.00	63,926,521.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,519,000.00	63,398,521.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,537,900.00	51,505,027.61
210101	Үндсэн цалин	37,643,100.00	37,847,948.00
210102	Нэмэгдэл	5,859,600.00	5,930,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,515,200.00	2,213,837.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,520,000.00	5,512,442.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,184,600.00	6,183,237.00
210201	Тэтгэврийн даатгал	4,123,100.00	4,316,260.00
210202	Тэтгэмжийн даатгал	515,400.00	469,523.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	412,300.00	375,659.00
210204	Ажилгүйдлийн даатгал	103,100.00	93,865.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,030,700.00	927,930.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,217,000.00	2,216,564.50
210401	Бичиг хэрэг	452,900.00	555,635.00
210402	Тээвэр, шатахуун	795,200.00	721,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	835,300.00	762,679.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	133,600.00	177,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	515,500.00	515,500.00
210604	Урсгал засвар	515,500.00	515,500.00
2107	Томилолт, зочны зардал	772,200.00	772,200.00
210702	Дотоод албан томилолт	772,200.00	772,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,747,300.00	1,661,492.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	297,000.00	213,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	336,600.00	335,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	103,900.00	103,142.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	990,000.00	990,000.00

Статистикийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	544500.00	544500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	544,500.00	544,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	528000.00	528000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	528,000.00	528,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	528,000.00	528,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	64,047,000.00	64,047,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	64,047,000.00	64,047,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	64,047,000.00	64,047,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	08.00	08.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	04.00	04.00
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00